



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2013 оны 15/07/025/51 дугаар актаар ашиглах, сэргээн засварлах боломжгүй нь тогтоогдсон, Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгыг 2019 онд нурааж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээ төвд хүүхдийн 50 ортой эмнэлэг барьсан тул нийт 4 нэрийн 10,151,488.49 (арван сая нэг зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун наян найман төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Стандарт хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Г.Мөнхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001413



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын
2021 оны 04 дүгээр сарын 04 өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Байршил	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Ашиглалтанд орсон огноо	Нэгжийн үнэ (төгрөг)	Балансын үнэ хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Конторын барилга	12/31/1953	Өвөрхангай аймаг Арвайхээр 13-р баг	1	ш	12/31/1953	9,246,767.15	9,246,767.15
2	Төмөр хашаа	7/1/2011		26	мкв	7/1/2011	4,117.00	107,058.46
3	Шилмүүст мод	7/1/2012		23	ш	7/1/2012	25,786.00	593,082.60
4	Явган хүний зам	7/2/2012		41.8	мкв	7/2/2012	4,894.00	204,580.28
	Нийт дүн							10,151,488.49
								(арван сая нэг зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун наян найман төгрөг дөчин есөн мөнгө)